

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/312/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/280

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны яамны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад харилцааны яамнаас Монгол Улсын Гадаад харилцааны яаманд өгсөн хандиваар ёслол хүндэтгэлийн "Их номин" танхимд 229,671.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Гадаад харилцааны яамны нэмэлт санхүүжилтийн дансанд 9,124,505.9 мянган төгрөг буюу яамны төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 86.4 хувьтай тэнцэх орлогын эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Гадаад харилцааны яамны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 54 зорилго дэвшүүлж, 196 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг дүгнүүлэхээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-20.Docx

0001050520

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,178,557,500.41	369,072,600.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,366,191.00	6,086,031.02
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	4,710.00
31110	Төгрөг	-	4,710.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,366,191.00	6,081,321.02
31210	Төгрөг	5,366,191.00	6,081,321.02
31211	Төрийн сангийн харилцах	4,237,191.00	4,237,191.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,129,000.00	1,844,130.02
33	АВЛАГА	546,145,360.00	115,307,322.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	540,151,604.00	109,557,494.00
33500	Бусад авлага	5,993,756.00	5,749,828.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	5,993,756.00	5,749,828.00
34	УРЬДЧИЛГАА	196,500,000.00	4,604,133.33
34600	Урьдчилж гарсан зардал	196,500,000.00	4,604,133.33
35	БАРАА МАТЕРИАЛ	430,545,949.41	243,075,114.37
35100	Түүхий эд материал	302,367,767.30	63,043,836.40
35110	Тусгай зориулалттай материал	302,367,767.30	63,043,836.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	15,749,452.62
35400	Хангамжийн материал	128,178,182.11	164,281,825.35
35410	Бичиг хэргийн материал	-	175,000.00
35450	Барилгын засварын материал	-	16,132,000.00
35470	Бусад хангамжийн материал	128,178,182.11	147,974,825.35
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,725,060,572.21	9,521,738,313.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,725,060,572.21	9,521,738,313.91
39200	Биет хөрөнгө	8,505,870,015.05	8,422,204,080.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,020,074,674.55	8,249,746,364.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(742,056,042.90)	(1,030,896,574.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,225,486,713.27	4,503,773,497.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,463,881,045.10)	(3,792,473,407.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,465,911,530.86	1,581,967,800.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,094,064,024.63)	(1,184,311,808.61)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	86,193,135.00	86,193,135.00
39217	Ном	8,205,074.00	8,205,074.00
39300	Биет бус хөрөнгө	1,219,190,557.16	1,099,534,233.10
39301	Програм хангамж	503,890,076.00	503,890,076.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(260,187,518.84)	(379,843,842.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	975,488,000.00	975,488,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,903,618,072.62	9,890,810,914.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,903,618,072.62	9,890,810,914.63
51	Засгийн газрын хувь оролцоо	10,903,618,072.62	9,890,810,914.63
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,330,370,602.25	3,330,370,602.25
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	3,330,370,602.25	3,330,370,602.25
51200	Хуримтлагдсан үр дүн	6,678,158,685.74	5,665,351,527.75
51210	Өмнөх үеийн үр дүн	6,444,679,642.42	6,678,158,685.74
51220	Тайлант үеийн үр дүн	233,479,043.32	(1,012,807,157.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	895,088,784.63	895,088,784.63

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,903,618,072.62	9,890,810,914.63
---	--	--------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	14,525,778,461.43	22,881,211,504.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931,087,493.00	1,309,554,776.04
120	Нийтлэг татварын бус орлого	931,087,493.00	1,309,554,776.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	931,087,493.00	1,309,554,776.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	929,643,293.00	1,215,697,022.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,444,200.00	93,857,754.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,594,690,968.43	21,571,656,728.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,123,426,356.00	13,495,811,718.72
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,123,426,356.00	13,495,811,718.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,471,264,612.43	8,075,845,009.98
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	950,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,425,301,955.93	7,733,377,163.98
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	95,962,656.50	342,467,846.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,780,332,294.85	23,894,018,662.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,780,332,294.85	23,894,018,662.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,536,752,463.39	18,060,580,036.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,593,942,343.88	5,017,123,805.18
210101	Үндсэн цалин	3,593,942,343.88	5,017,123,805.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	454,848,633.95	615,864,333.28
210201	Тэтгэврийн даатгал	454,848,633.95	615,864,333.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,255,298.64	218,204,140.45
210301	Гэрэл, цахилгаан	85,983,072.51	100,818,646.92
210302	Түлш, халаалт	77,525,652.13	94,447,860.25
210303	Цэвэр, бохир ус	23,746,574.00	22,937,633.28
2104	Хангамж, бараа материалын зардал	183,779,739.66	179,320,600.31
210401	Бичиг хэрэг	54,872,427.00	52,136,385.00
210402	Тээвэр, шатахуун	42,681,756.51	53,015,927.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,684,760.15	74,168,287.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,750,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	790,796.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,859,546.30	50,556,949.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,102.00	761,000.00
210604	Урсгал засвар	30,803,444.30	49,795,949.20
2107	Томилолт, зочны зардал	1,027,435,145.26	1,956,177,725.58
210701	Гадаад албан томилолт	802,977,102.08	1,610,751,173.20
210702	Дотоод албан томилолт	6,592,176.15	8,122,302.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	217,865,867.03	337,304,250.38

Гадаад харилцааны яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	547,822,321.83	1,301,158,451.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	498,329,537.83	1,270,908,498.05
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,374,759.00	26,728,615.11
210807	Газрын төлбөр	47,118,025.00	3,521,338.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,510,809,433.87	8,722,174,031.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,601,931,303.48	7,894,837,029.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,447,900.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	906,430,230.39	827,337,002.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,243,579,831.46	5,833,438,625.74
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,212,663,243.95	1,727,696,439.58
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,212,663,243.95	1,727,696,439.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,969,944.12	68,605,593.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,680,000.00	8,150,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,828,444.12	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	10,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,461,500.00	49,955,593.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,217,866,642.39	3,111,028,799.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,113,712,490.30	3,032,897,892.22
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	101,389,652.09	78,130,907.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	2,764,500.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	734,080,001.00	926,107,793.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	734,080,001.00	926,107,793.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	745,446,166.58	(1,012,807,157.99)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	511,967,123.26	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	511,967,123.26	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	233,479,043.32	(1,012,807,157.99)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	15,063,029,812.20	23,642,904,128.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	930,003,552.20	1,022,586,524.04
120	Нийтлэг татварын бус орлого	930,003,552.20	1,022,586,524.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	930,003,552.20	1,022,586,524.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	930,003,552.20	1,022,586,524.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,133,026,260.00	22,620,317,604.52
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,123,426,356.00	13,495,811,718.72
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,123,426,356.00	13,495,811,718.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,009,599,904.00	9,124,505,885.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	992,839,907.50	540,151,604.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,807,491,880.00	7,958,499,009.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,202,500.00	90,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	96,065,616.50	535,855,272.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,217,917,011.96	23,112,027,298.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,217,917,011.96	23,112,027,298.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,051,995,652.43	17,155,331,837.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,600,491,859.06	5,055,345,664.71
210101	Үндсэн цалин	2,216,029,518.30	3,044,495,325.40
210102	Нэмэгдэл	1,020,908,833.17	1,712,809,523.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	255,773,084.89	261,173,000.00
210104	Урамшуулал	107,780,422.70	36,867,815.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	447,958,021.83	577,642,473.75
210201	Тэтгэврийн даатгал	309,491,977.47	386,017,673.75
210202	Тэтгэмжийн даатгал	33,027,260.23	47,906,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,764,969.35	38,325,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,133,997.07	9,581,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	71,539,817.71	95,812,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,255,298.64	219,855,740.45
210301	Гэрэл, цахилгаан	85,983,072.51	100,818,646.92
210302	Түлш, халаалт	77,525,652.13	94,447,860.25
210303	Цэвэр, бохир ус	23,746,574.00	24,589,233.28
2104	Хангамж, бараа материалын зардал	209,805,785.49	218,815,553.31
210401	Бичиг хэрэг	52,855,439.00	64,236,079.00
210402	Тээвэр, шатахуун	50,830,613.54	53,015,927.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,684,760.15	74,168,287.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,750,000.00	5,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,684,972.80	21,995,259.00

Гадаад харилцааны яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,931,546.30	304,126,418.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	128,102.00	43,146,409.60
210602	Тавилга	0.00	2,250,000.00
210604	Урсгал засвар	30,803,444.30	258,730,009.20
2107	Томилолт, зочны зардал	1,010,291,042.32	1,806,951,338.40
210701	Гадаад албан томилолт	798,045,464.08	1,604,511,073.20
210702	Дотоод албан томилолт	5,753,626.15	10,391,285.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	206,491,952.09	192,048,980.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	946,937,529.31	758,482,420.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	897,444,745.31	723,320,333.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,374,759.00	31,640,748.44
210807	Газрын төлбөр	47,118,025.00	3,521,338.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,618,324,569.48	8,214,112,228.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,615,876,669.48	8,214,112,228.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,447,900.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,165,921,359.53	5,956,695,460.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,212,663,243.95	1,727,696,439.58
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,212,663,243.95	1,727,696,439.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,969,944.12	69,133,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,100,000.00	7,650,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,828,444.12	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	10,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,041,500.00	50,983,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,140,208,170.46	3,220,586,293.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,116,476,990.30	3,032,897,892.22
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,023,731,180.16	187,688,401.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	734,080,001.00	939,279,728.05
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	734,080,001.00	939,279,728.05
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	845,112,800.24	530,876,830.02
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	843,992,800.24	530,156,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	843,992,800.24	530,156,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	843,992,800.24	530,156,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	843,992,800.24	530,156,990.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(843,992,800.24)	(530,156,990.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,120,000.00	719,840.02
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,246,191.00	5,366,191.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,366,191.00	6,086,031.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	6,678,158,685.74	10,903,618,072.62
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	6,678,158,685.74	10,903,618,072.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	6,678,158,685.74	10,903,618,072.62
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,012,807,157.99)	(1,012,807,157.99)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	5,665,351,527.75	9,890,810,914.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,118,529,700.00	10,558,672,716.58	9,559,856,983.42	52.48
УРСГАЛ ЗАРДАЛ	20,118,529,700.00	10,558,672,716.58	9,559,856,983.42	52.48
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,966,746,600.00	8,761,843,277.00	7,204,903,323.00	54.88
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,090,620,600.00	4,887,040,505.42	203,580,094.58	96.00
Үндсэн цалин	2,933,510,700.00	2,876,190,166.11	57,320,533.89	98.05
Нэмэгдэл	1,799,806,600.00	1,712,809,523.61	86,997,076.39	95.17
Унаа хоолны хөнгөлөлт	298,920,000.00	261,173,000.00	37,747,000.00	87.37
Урамшуулал	58,383,300.00	36,867,815.70	21,515,484.30	63.15
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	598,827,700.00	569,655,093.75	29,172,606.25	95.13
Тэтгэврийн даатгал	407,202,900.00	378,030,293.75	29,172,606.25	92.84
Тэтгэмжийн даатгал	47,906,200.00	47,906,200.00	-	100.00
ҮОМШӨ-ний даатгал	38,325,000.00	38,325,000.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	9,581,300.00	9,581,300.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	95,812,300.00	95,812,300.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,717,600.00	219,855,740.45	107,861,859.55	67.09
Гэрэл, цахилгаан	137,307,200.00	100,818,646.92	36,488,553.08	73.43
Түлш, халаалт	126,947,600.00	94,447,860.25	32,499,739.75	74.40
Цэвэр, бохир ус	63,462,800.00	24,589,233.28	38,873,566.72	38.75
Хангамж, бараа материалын зардал	234,884,300.00	202,143,553.31	32,740,746.69	86.06
Бичиг хэрэг	65,964,100.00	63,564,079.00	2,400,021.00	96.36

Гадаад харилцааны яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тээвэр, шатахуун	55,506,800.00	53,015,927.60	2,490,872.40	95.51
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,683,300.00	74,168,287.71	12,515,012.29	85.56
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,232,700.00	5,400,000.00	7,832,700.00	40.81
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,497,400.00	5,995,259.00	7,502,141.00	44.42
Эд хогшил, урсгал засварын зардал	273,513,800.00	193,054,916.80	80,458,883.20	70.58
Багаж, техник, хэрэгсэл	252,270,300.00	172,798,849.60	79,471,450.40	68.50
Урсгал засвар	21,243,500.00	20,256,067.20	987,432.80	95.35
Томилолт, зочны зардал	2,975,459,700.00	1,769,437,568.80	1,206,022,131.20	59.47
Гадаад албан томилолт	2,675,861,900.00	1,569,237,573.60	1,106,624,326.40	58.64
Дотоод албан томилолт	10,939,700.00	10,391,285.00	548,415.00	94.99
Зочин төлөөлөгч хүлээн авах	288,658,100.00	189,808,710.20	98,849,389.80	65.76
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,869,251,400.00	654,702,680.24	5,214,548,719.76	11.15
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,222,932,600.00	619,540,593.80	4,603,392,006.20	11.86
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	593,388,000.00	31,640,748.44	561,747,251.56	5.33
Газрын төлбөр	52,930,800.00	3,521,338.00	49,409,462.00	6.65
Бараа үйлчилгээний бусад зардал	596,471,500.00	265,953,218.23	330,518,281.77	44.59
Бараа үйлчилгээний бусад зардал	593,824,200.00	265,953,218.23	327,870,981.77	44.79
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,647,300.00	-	2,647,300.00	0.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,151,783,100.00	1,796,829,439.58	2,354,953,660.42	43.28
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,941,277,200.00	1,727,696,439.58	2,213,580,760.42	43.84
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,941,277,200.00	1,727,696,439.58	2,213,580,760.42	43.84
Бусад урсгал шилжүүлэг	210,505,900.00	69,133,000.00	141,372,900.00	32.84
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,917,800.00	7,650,000.00	8,267,800.00	48.06
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	138,490,400.00	10,500,000.00	127,990,400.00	7.58
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,097,700.00	50,983,000.00	5,114,700.00	90.88
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,118,529,700.00	10,558,677,426.58	9,559,852,273.42	52.48
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,118,529,700.00	10,462,913,826.50	9,655,615,873.50	52.01
Улсын төсвөөс санхүүжих	20,118,529,700.00	10,462,913,826.50	9,655,615,873.50	52.01
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	95,763,600.08	(95,763,600.08)	0.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	95,763,600.08	(95,763,600.08)	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,366,191.00	(5,366,191.00)	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,086,031.02	(6,086,031.02)	0.00

Гадаад харилцааны яамны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

АЖИЛЛАГСАДЫН ТОО	147	147	-	100.00
Удирдах ажилтан	10	10	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	123	123	-	100.00
Үйлчлэх ажилтан	14	14	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	9,124,505,885.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	9,124,505,885.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8,923,645,550.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	168,305,159.29
210101	Үндсэн цалин	-	168,305,159.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	7,987,380.00
210201	Тэтгэврийн даатгал	-	7,987,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	16,672,000.00
210401	Бичиг хэрэг	-	672,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	16,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	401,216,802.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	55,776,290.00
210602	Тавилга	-	37,339,050.00
210604	Урсгал засвар	-	308,101,462.00
2107	Томилолт, зочны зардал	-	37,513,769.60
210701	Гадаад албан томилолт	-	35,273,499.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	2,240,270.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	333,451,430.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	333,451,430.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,958,499,009.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,958,499,009.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200,860,335.11
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	200,860,335.11
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	187,688,401.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,171,934.11
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	9,124,505,885.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,124,505,885.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	540,151,604.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,958,499,009.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	90,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	535,855,272.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4.6 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 4.6 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэг жилийн хугацаатай 13,812.4 мянган төгрөгийн программ хангамжийн лиценз худалдан авч шууд зардлаар бүртгэж, тайлант онд ногдохгүй 4,604.1 мянган төгрөгийн зардлыг дараа онд хуваарилж бүртгээгүй байна.	1	4,604.1			1	4,604.1	1	4,604.1				
Дүн	1	4,604.1			1	4,604.1	1	4,604.1				

Аудитаар нийт 2.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд төсөвт орлого төвлөрүүлэхээр төлөвлөлгүй, туслах үйл ажиллагаанаас 1,215,697.0 мянган төгрөгийн орлого олж, 193,354.4 мянган төгрөгийг давсан орлогоор тооцож үйл ажиллагаандаа зарцуулсан байна.	1	-					1	-				
Байгууллагын төсвөөс 2,403.2 мянган төгрөгийн хэмнэлтийн бусад арга хэмжээнд тусгагдсан зүйлийг худалдаж авсан байна.	1	2,403.2					1	2,403.2				
Дүн	2	2,403.2					2	2,403.2				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий гэрээний дагуу худалдан авах бараа, үйлчилгээний худалдан авалтын захиалгыг бэлтгэж, мэргэжлийн байгууллагад хүргүүлээгүй байна.	1	-			1	-
Тайлант онд тендерийн баримт бичигт тусгагдсан гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, ажил гүйцэтгүүлсэн байна.	1	-			1	-
Дүн	2				2	